




НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САН
UNITED NATIONS CHILDREN'S FUND



АМЖИЛТЫН ЭЗЭД ХХК
LORDS OF SUCCESS LLC

ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ЦОЧРОЛД ХАРИУ ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ӨРХИЙН СУДАЛГАА

Улаанбаатар 2020

АГУУЛГА

1. ОРШИЛ.....	4
2. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	4
2.1. Судалгааны зорилго	4
2.2. Судалгааны хамрах хүрээ, түүврийн дизайн, зохион байгуулалт	4
2.2.1. Судалгааны хамрах хүрээ	4
2.2.2. Судалгааны түүврийн дизайн	4
2.2.3. Судалгааны бэлтгэл, зохион байгуулалт	5
3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	5
3.1. Судалгааны хамрагдалт.....	5
3.2. Судалгааны үр дүн	7
3.2.1. Мэдээлэл түгээлт, харилцаа.....	7
3.2.2. Мөнгөний зарцуулалт, мөнгө олгосон хугацаа:.....	12
3.2.3. Сэтгэл ханамж.....	15
4. ДҮГНЭЛТ	16
ХАВСРАЛТ 1. ҮР ДҮНГИЙН ХҮСНЭГТҮҮД.....	17
ХАВСРАЛТ 2. СУДАЛГААНЫ АСУУЛГА.....	23

ТОВЧИЛСОН ҮГ

ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ТВ	Телевиз

1. ОРШИЛ

НҮБ-ын Хүүхдийн Сан нь Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам (ХНХЯ), Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар (ЗДТГ)-тай хамтран цаг уурын хүндрэл, цочролын үед хүүхдийг хамгаалах нийгмийн хамгааллын тогтолцоог хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж байна.

Энэ ажлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлж буй Хүүхдийн мөнгөний хөтөлбөрийн дансаар дамжуулан зорилтот бүлгийн хүүхдүүдэд мөнгөн тусламж хүргэх туршилтын ажлыг 2019 оны 12-р сард хэрэгжүүлсэн. Уг туршилтын ажилд Завхан аймгийн Баянтэс, Их-Уул, Тосонцэнгэл, Тэс сумдын харьяат 0-5 насны 2783 хүүхдэд мөнгөн тусламж олгосон юм.

Уг туршилтын ажлын хэрэгжилтийг хянах зорилгоор зохион байгуулсан өрхөд суурилсан түүвэр судалгааны үр дүнг энэхүү тайлангаар танилцуулж байна.

2. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Судалгааны зорилго

Энэхүү ажлын зорилго нь хүүхдийн мөнгөний хөтөлбөрийн дансаар дамжуулан зорилтот бүлгийн хүүхдүүдэд мөнгөн тусламж хүргэх туршилтын ажлын хэрэгжилтийг хянах зорилгоор өрхөд суурилсан түүвэр судалгааг зохион байгуулан явуулахад оршино.

2.2. Судалгааны хамрах хүрээ, түүврийн дизайн, зохион байгуулалт

2.2.1. Судалгааны хамрах хүрээ

Судалгааны эх олонлог нь туршилтын ажилд хамрагдсан 2783 хүүхэд бөгөөд түүврийн хэмжээ 400 өрх байлаа. Түүврийн хэмжээг НҮБ-ын Хүүхдийн сангаас тогтоож, судалгаанд хамрагдах өрхүүдийн жагсаалтыг бидэнд ирүүлсэн.

2.2.2. Судалгааны түүврийн дизайн

Түүврийн дизайн, түүврийн хэмжээ: Судалгааны түүврийн дизайныг боловсруулахад магадлалт, энгийн санамсаргүй түүврийн аргыг ашигласан.

Түүврийн хэмжээ нь 95.0 хувийн итгэх мужид стандарт алдаа 2.6 хувь, алдааны хязгаар 15.0 хувь, түлхүүр үзүүлэлт нь 0.35 байхад 330 өрх, түүврийн хэмжээний хорогдох хувь хэмжээг 15.0 хувь гэж үзэхэд 388 өрх байсан бөгөөд

судалгаанд сонгогдсон 4 сумын харьцуулагдах байдлыг харгалзан үзэж тэгш хуваарилалтын аргыг хэрэглэж, 400 өрхөөр түүврийн хэмжээг тогтоолоо.

2.2.3. Судалгааны бэлтгэл, зохион байгуулалт

Судалгааны бэлтгэл: Судалгааны мэдээлэл цуглуулахын өмнө манай байгууллага нь НҮБ-ын Хүүхдийн сантай 2020 оны 01-р сарын 21-ний өдөр хамтран ажиллах гэрээг байгуулж бэлтгэл ажлыг ханган ажиллаж, судалгааны ажлыг дараах байдлаар зохион байгуулсан.

Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт: Судалгаанд хамрагдвал зохих нийт 400 өрхтэй холбоо барьж мэдээллийн санг бүрдүүлсэн. Гэхдээ судалгааны зорилго, захиалагчаас өгсөн чиглэлийн дагуу шаардлага хангасан 366 өрхийн мэдээллээс эцсийн үр дүнг энэхүү тайлангаар танилцуулж байна. Мэдээллийг оруулах, шалгах, засварлах программ хангамжийг CsPro 7.2.1 программ хангамжийг ашиглан боловсруулж, мэдээллийг оруулахад бэлэн болгосон. Тус программ хангамжид ярилцлагын явцад гарах аливаа алдаанаас сэргийлж асуулгын дагуу боломжит логик шалгалт, үсрэлтүүдийг оруулж, шалгалтыг хийж мэдээллийн санг бүрдүүлж, үр дүнгийн хүснэгтүүд авах боломжийг бүрдүүлсэн.

Судалгааны хугацаа: Захиалагчтай гэрээ байгуулснаас хойш хоёр долоо хоногийн хугацаанд мэдээллийг цуглуулж, нийт 3 долоо хоногийн хугацаанд мэдээллийн боловсруулалт, үр дүнг гаргаж, тайланг боловсруулж дууслаа.

3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1. Судалгааны хамрагдалт


Судалгаанд Завхан аймгийн Баянтэс, Их-Уул, Тосонцэнгэл, Тэс сумын нийт 366 өрх хамрагдаж, хамралт нь 91.5 хувь байлаа. Эдгээр өрхүүдийн 57.9 хувь нь сумын төвд, 42.1 хувь нь хөдөө амьдарч байна.

ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ӨРХИЙН ТОО, сум, байршлаар

Сумын нэр	БҮГД	Сумын төв	
		Сумын төв	Хөдөө
БҮГД	366	212	154
Баянтэс	95	51	44
Их-Уул	94	45	49
Тосонцэнгэл	82	59	23
Тэс	95	57	38


Судалгаанд оролцогчдыг сонгохдоо захиалагчийн өгсөн чиглэлийн дагуу арга хэмжээний хүрээнд олгосон тусламжийн мөнгийг банкнаас авсан, зарцуулсан гишүүнийг олж толорхойлсон.

ЗУРАГ 1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИД, 0-5 настай хүүхдийн хамаарлын байдлаар



Судалгаанд оролцогчдын 90.4 хувь нь зорилтот бүлгийн хүүхдүүдийн эцэг, эх нь байсан. Мөн тэдний 77.0 хувь нь гэрийн эзэгтэй нар байна. Энэ нь сумдад өрхийн тэргүүнээс илүү эзэгтэй нар хүүхдүүддээ хувцас, хүнсийг нь бэлтгэдэг бөгөөд малчин өрхийн гэрийн эзэд оторт явж, эхнэр нь хүүхдүүдээ асран гэртээ үлддэгтэй холбоотой байна.

ЗУРАГ 2. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИД, оролцогчийн насны бүлэг, хүйсээр



Судалгаанд оролцогчдын 47.5 хувь нь 25-34 насны залуучууд, 41.8 хувь нь 35-49 насныхан зонхилж байна. Мөн бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр бөгөөд 71.0 ба түүнээс дээш хувийг эзэлж байна.


3.2. Судалгааны үр дүн

3.2.1. Мэдээлэл түгээлт, харилцаа

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 95.9 хувь нь үндсэн 12 эх сурвалжаас тус арга хэмжээний талаарх мэдээллийг авсан гэж үзэхээр байна. Иргэдийн 26.1 хувь нь тус арга хэмжээний талаар хамгийн түрүүнд олон нийтээс буюу албан бус эх сурвалжаас мэдээлэл авсан бол хамгийн үнэн бодит мэдээллийг банкнаас (19.4 хувь нь) авсан байна.


Судалгаагаар арга хэмжээний талаарх мэдээллийг хамгийн анх сонссон, мөн бодит мэдээлэл авсан мэдээллийн эх сурвалжийг тус бүрд нь асуусан юм. Анх сонссон болон бодит мэдээллийг авсан эх сурвалжийг харьцуулвал судалгаанд хамрагдсан өрхүүдийн 69.7 хувь нь анхны эх сурвалжаасаа шууд бодит мэдээлэл авсан. Үлдсэн хэсгийн дийлэнх нь анх бусдын ярианаас сонссон иргэд бөгөөд тэд мэдээллийг баталгаажуулах зорилгоор банк, нийгмийн халамжийн мэргэжилтэн, багийн засаг дарга нарт хандсан байна. Бусад эх сурвалжаас мэдээлэл авсан иргэд ерөнхийдөө шууд бодит мэдээлэл авсан байна.

ЗУРАГ 3. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ, хувиар



Сумдаар үр дүнг харьцуулан харвал нөхцөл байдалтай ялгаатай байна. Бүх суманд мэдээллийг анх сонссон эх сурвалж нь бусдын ярианаас байгаа юм. Бусад эх сурвалжийг харвал, Баянтэс суманд сумын засаг дарга, ТВ, радио, Их-Уул суманд банк, төрийн албан хаагчид, Тосонцэнгэл суманд сумын засаг дарга, банк, Тэс суманд ТВ, радио, багийн засаг дарга, төрийн албан хаагчид нь хамгийн их хүнд мэдээлэл түгээжээ.


ЗУРАГ 4. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ, сумаар



Мэдээллийн эх сурвалжийн чанарыг авч үзвэл, мэдээлэл хүргэх арга замууд нь сумын төвийн болон хөдөөгийн өрхүүдэд ялгаатай байна. Сумын төвийн өрхүүдийн хувьд сумын засаг дарга, банк, сумын төрийн албан хаагчид, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл авах нь ихэнх хувийг эзэлж байгаа бол хөдөөгийн өрхүүдэд мэдээлэл хүргэх гол эх сурвалж нь банк, багийн засаг дарга, төрийн бусад албан хаагчид болон телевиз байжээ. Иргэдийн мэдээллийг анх сонссон эх сурвалж нь байршлаас үл хамааран бусдаас буюу албан бус эх сурвалж байгаа боловч үнэн бодит мэдээллийг албан эх сурвалжаас лавласан нь тус бүрд 9.0 орчим пункт байна.

Албан эх сурвалжуудын хувьд анхны мэдээлэл хүргэсэн эх сурвалж иргэдэд шууд бодит мэдээлэл өгсөн гэж үзэж болохоор байна.

ЗУРАГ 5. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ, суурьшлаар




Дараах хүснэгтээс харахад орлогын ихэнх хэсэг нь МАА-с бүрддэг өрхийн мэдээллийн анхны эх сурвалж нь бусад иргэд буюу албан бус эх сурвалж (27.4 хувь) байсан бол бодит мэдээлэл авсан гол эх сурвалж нь банк (19.8 хувь) байсан байна.

ХҮСНЭГТ 2. МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ, орлогын ангиллаар

Мэдээллийн эх сурвалж	Орлогын эх үүсвэр			
	МАА		МАА-н бус	
	Анх сонссон	Үнэн бодит	Анх сонссон	Үнэн бодит
Сумын засаг дарга	10.0	10.1	24.0	20.8
Банк	12.6	19.8	12.5	18.8
Сумын Facebook групп	3.3	2.2	8.3	7.3
Мал тооллогын комисс	3.0	3.4	0.0	0.0
Багийн засаг дарга	10.7	10.8	5.2	9.4
Нийгмийн халамжийн мэргэжилтэн	3.0	3.7	3.1	8.3
Цэцэрлэгийн багш	1.9	1.9	2.1	4.2
Сумын бусад төрийн албан хаагч	11.1	11.9	7.3	6.3
Бусдын ярианаас	27.4	17.9	22.9	15.6
ТВ, радио	11.9	12.3	4.2	4.2
Ямар ч мэдээлэл авааг	2.2	3.4	8.3	5.2
Бусад /Тодорхой бичнэ	3.0	2.6	2.1	0.0

Судалгааны үр дүнгээс харахад, албан эх сурвалжуудын аль нь ч төдийлөн буруу ташаа мэдээлэл түгээсэн байдал ажиглагдсангүй. Өөрөөр хэлбэл, хэдийгээр давтамжийн хувьд цөөхөн боловч цэцэрлэгийн багш, мал тооллогын комиссоос анх мэдээлэл авсан бүх иргэд тэрхүү мэдээлэл нь зөв байсан гэж үзсэн бол сумдын төрийн албан хаагчдаас мэдээлэл авсан иргэдийн 86.5 хувь, сумын засаг даргаас мэдээлэл сонссон иргэдийн 86.0 хувь, нийгмийн халамжийн мэргэжилтнээс мэдээлэл авсан иргэдийн 81.8 хувь нь тус тус бүрэн зөв мэдээлэл өгсөн гэж судалгаанд оролцогчид үзжээ.

ЗУРАГ 6. МЭДЭЭЛЛИЙН АНХНЫ ЭХ СУРВАЛЖЫН ҮНЭН БОДИТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ, суурьшлаар




Өрхүүдээс арга хэмжээний зорилгыг хэрхэн ойлгосныг асуухад өрхүүдийн 52.5 хувь нь зудтай/өвөлжилт хүндэрсэн сумдын хүүхдүүдэд зориулсан, 30.1 хувь нь зөвхөн хүүхдүүдэд зориулсан гэж ойлгосон бол 11.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

ХҮСНЭГТ 3. АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОРИЛГЫН ОЙЛГОЛТ

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Нийт	383	100.0	-
Зудтай/ өвөлжилт хүндэрсэн сумдын хүүхдүүдэд зориулсан	192	50.1	52.5
Зөвхөн хүүхдүүдэд	110	28.7	30.1
Өрхийн өвөлжилтийг давахад	15	3.9	4.1
Бусад	23	6.0	6.3
Мэдэхгүй	43	11.2	11.8
Түүврийн хэмжээ			366


Сумдаар авч үзвэл хүн ам цөөн 2 сумын өрхүүд 82.0-88.0 орчим хувь нь арга хэмжээний мөнгийг хүүхдүүдэд зарцуулах ёстой гэж ойлгосон бол нөгөө 2 суманд энэ үзүүлэлт 75.6-77.4 хувь байна. Их-Уул сумын өрхүүдийн 62.4 хувь нь зудтай/цаг уурын хүндрэлтэй сумдын хүүхдүүдэд зориулсан арга хэмжээ хэрэгжүүлсэн гэдэг мэдээллийг авсан байгаа нь бусад сумдаас харьцангуй өндөр үзүүлэлт юм.

ЗУРАГ 7. АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОРИЛГЫН ОЙЛГОЛТ, сумаар



Арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгийн хүн амд мөнгөн тусламж 2019 оны 12-р сарын 09-ний өдөр дансанд нь орсон.


ЗУРАГ 8. МЭДЭЭЛЭЛ АВСАН ХУГАЦАА, байршлаар



Мэдээллийг хүлээн авсан цаг хугацааны хувьд өрхүүдийн 44.1 хувь нь арга хэмжээний мөнгө хүүхдийн мөнгөний дансанд орохоос өмнө авсан бол талаас илүү нь мөнгө орсны дараа мэдээлэл авсан байна. Сумын төвийн өрхүүдийн 51.3 хувь нь мөнгө орсны дараа мэдээлэл авсан бол хөдөөгийн өрхүүдэд уг үзүүлэлт 6.1 пунктээр илүү байна.

Сумдаар авч үзвэл зөвхөн Баянтэс сумын иргэдийн талаас илүү нь (61.5 хувь) нь мөнгө дансанд орохоос өмнө мэдээлэл авч амжсан бол бусад 3 суманд талаас илүү нь мөнгө орсны дараа авсан байна.

ХҮСНЭГТ 9. МЭДЭЭЛЭЛ АВСАН ХУГАЦАА, сумаар



3.2.2. Мөнгөний зарцуулалт, мөнгө олгосон хугацаа:

Арга хэмжээний гол зорилго нь тусламжаар олгосон мөнгийг цаг агаар хүндрэхээс өмнө зорилтот бүлгийн хүүхдүүдийн өвөлжилтийн бэлтгэлийг хангах явдал байсан. Арга хэмжээний тухай өрхөд хүргэх мэдээллийн хүртээмж сайн байгаа нь мөнгөний зарцуулалтад шууд нөлөөлжээ. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 65.9 хувь нь мөнгийг тухайн эзэнд нь, 12.8 хувь нь бүх хүүхдэдээ зориулж зарцуулжээ.

ЗУРАГ 10. МӨНГӨНИЙ ЗОРИУЛАЛТ, хувиар



Судалгаагаар арга хэмжээний хүрээнд авсан мөнгөө өрхүүд хэрхэн зарцуулсныг тодруулсан. Хэрэглээг хэмжихдээ мөнгөн дүнгээр хамгийн их зарцуулалттай 2 бүлгийг асуусан.

Өрхүүдийн 53.3 хувь нь мөнгөний ихэнх хэсгийг хүүхдийн гутал, хувцас, эрүүл мэндэд нь зориулан зарцуулсан. Мөн өрхүүдийн 15.3 хувь нь хүүхдийн хадгаламжийн дансруу шууд хийжээ.

Тухайн хүүхдэд шууд бус буюу өрхийн дундын хэрэглээ хүнс, гэрээ дулаалах, түлээ, түлш авах зэрэгт нийт өрхийн 11.7 хувь нь мөнгөний дийлэнх хэсгийг зарцуулсан байна. Өрхүүдийн 56.5 хувь нь мөнгийг нэг төрлийн худалдан авалт, үйлчилгээнд зарцуулжээ.

ЗУРАГ 11. МӨНГӨНИЙ ДИЙЛЭНХ ХЭСГИЙН ЗАРЦУУЛАЛТ, хувиар



Өрхүүдийн 43.4 хувь нь арга хэмжээний хүрээнд олгосон мөнгийг нэгээс илүү төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээнд зарцуулсан. Тухайлбал, эдгээр өрхүүдийн 34.6 хувь нь үлдэгдэл мөнгийг хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ, эм авахад зарцуулсан бол 32.7 хувь нь хүнсний зүйлд, 20.1 хувь нь гутал, хувцас авахад зарцуулж, 1.9 хувь нь мөнгөний зарим хэсгийг хадгаламжинд хийсэн байв.

ЗУРАГ 12. МӨНГӨНИЙ ХОЁР ДАХЬ ҮНДСЭН ЗАРЦУУЛАЛТ, хувиар



Хүүхдийн мөнгөний дансанд арга хэмжээний мөнгө 2019 оны 12-р сарын 09-ний өдөр орсон талаар өмнө нь дурдсан билээ. Тус хугацаанд өвөлжилтийн бэлтгэлийг хангах зорилгоор хүүхдэд тусламж олгох нь тохиромжтой эсэхийг тодруулахад судалгаанд хамрагдсан өрхүүдийн 95.1 хувь нь “Яг зөв үед” гэж хариулсан.

Ер нь судалгааны ярилцлагын үед өрхүүд мөнгөн тусламж үзүүлэх нь цаг хугацааны хувьд тохиромжтой, тохиромжгүй гэх явдал үгүй, хүний хэрэглээ байнга л байдаг гэсэн байх суурьтай байсан болно.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 23.8 хувь нь тухайн хугацаанд аль нэг дэлгүүрт өргүй байсан. Харин дэлгүүрт өртэй байгаа өрхүүдээс тусламжийн мөнгийг хүүхдүүддээ зарцуулахад дэлгүүр өрөө нэхэх эсэхэд санаа зовж байгаа эсэхийг тодруулсан. Өртэй байгаа өрхүүдийн 24.4 хувь нь өр нэхэх вий хэмээн санаа зовж байгаа бол 74.5 хувь нь үүнд санаа зовохгүй байв.


Нийт өрхүүдийн 37.3 хувь, үүнээс хөдөөгийн өрхүүдийн 46.1 хувь нь ЗГ, орон нутгаас олгосон малын тэжээлээс хөнгөлөлттэй үнээр худалдан авсан байв. Харин уг тэжээлээс авсан өрхүүдийн 5.1 хувь нь тус арга хэмжээний мөнгийг малын тэжээл авахад зарцуулсан гэж хариулжээ.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 97.6 хувь нь өөр бусад байгууллагын ямар ч тусламжид хамрагдаагүй байна.

3.2.3. Сэтгэл ханамж

Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээний энэ удаагийн туршилтад хамрагдсан өрхүүд ерөнхийдөө сэтгэл ханамжтай байна. Тухайлбал, нийт өрхийн 96.2 хувь сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн байна.

ЗУРАГ 13. СЭТГЭЛ ХАНАМЖИЙН БАЙДАЛ, хувиар



Харин өрхүүдийн 3.0 хувь нь сэтгэл ханамж дунд зэрэг байгаа бол 0.8 хувь нь зарим талаараа сэтгэл хангалуун бус байгаа юм. Эдгээр өрхүүдийн шалтгааныг харвал мөнгөний хэмжээ, зорилтот бүлгийн хүүхдийг сонгосон байдал, мэдээлэл хүргэсэн байдал, өрхийн нэг хүүхдэд нь мөнгө олгогдоогүй, малдаа тэжээл авахад хүрэлцээгүй, мөнгийг хүүхдэдээ зориулж зарцуулж чадаагүй зэрэг шалтгаантай байна.

ХҮСНЭГТ 4. СЭТГЭЛ ХАНГАМЖГҮЙ БАЙДЛЫН ШАЛТГААН, шалтгааны төрлөөр

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
БҮГД	18	100.0	-
Хүүхдийг сонгосон байдал (хүүхдийн нас, сумын сонголт)	5	27.8	35.7
Мэдээлэл хүргэсэн байдал/ харилцаа	3	16.7	21.4
Мөнгөний хэмжээ	6	33.3	42.9
Бусад	4	22.2	28.6

4. ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 95.9 хувь нь үндсэн 12 эх сурвалжаас тус арга хэмжээний талаарх мэдээллийг авсан байна. Мөн өрхүүдийн 69.7 хувь нь анхны эх сурвалжаас шууд бодит мэдээлэл авсан бөгөөд үүнд албан эх сурвалжуудын мэдээллийн чанар нөлөөлжээ.

Арга хэмжээний хүрээнд олгосон тусламжийн мөнгө 2019 оны 12-р сарын 09-ний өдөр хүүхдийн мөнгөний дансанд шилжин орсон бөгөөд өрхүүдийн 44.1 хувь нь тус хугацаанаас өмнө мэдээлэл авсан байгаа нь цаашид мэдээллийг хүртээмжийг анхаарах хэрэгтэйг харуулж байна.

Арга хэмжээний хүрээнд олгосон мөнгөний зарцуулалтын хувьд, судалгаанд хамрагдсан өрхүүдийн 65.9 хувь нь тухайн хүүхдэд, 12.8 хувь нь өөрийн бүх хүүхдэдээ зориулсан байна. Энэ нь мэдээллийн чанартай холбоотой байж болох юм. Өрхүүдийн гуравны нэг нь хүүхдийн хувцас, гутал авахад мөнгөө зарцуулсан бол таван өрх тутмын нэг нь хүүхдүүддээ эрүүл мэндийн үйлчилгээ, эм, амин дэм авч өгчээ. Зарцуулалтыг харахад нийт өрхийн 80.0 орчим хувь нь тухайн хүүхдэд хүртээмжтэйгээр бараа, бүтээгдэхүүн үйлчилгээ худалдан авжээ.

Мөнгийг хүүхдийн мөнгөний дансанд байршуулсан хугацааг өрхүүдийн 95.1 хувь нь “Яг зөв үед” хариулсан. Гэхдээ судалгааны ярилцлагын үед өрхүүд мөнгөн тусламж үзүүлэх нь цаг хугацааны хувьд тохиромжтой, тохиромжгүй гэх явдал үгүй, хүний хэрэглээ байнга л байдаг гэсэн байх суурьтай байна.

Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээний энэ удаагийн туршилтад хамрагдсан нийт өрхүүдийн 96.2 хувь сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн байна.

Харин өрхүүдийн 3.0 хувь нь сэтгэл ханамж дунд зэрэг байгаа бол 0.8 хувь нь зарим талаараа сэтгэл хангалуун бус байгаа юм. Эдгээр өрхүүдийн шалтгааныг тодруулбал, мөнгөний хэмжээ, зорилтот бүлгийн хүүхдийг сонгосон байдал, мэдээлэл хүргэсэн байдал, өрхийн нэг хүүхдэд нь мөнгө олгогдоогүй, малдаа тэжээл авахад хүрэлцээгүй, мөнгийг хүүхдэдээ зориулж зарцуулж чадаагүй зэрэг шалтгаантай байна.

ХАВСРАЛТ 1. ҮР ДҮНГИЙН ХҮСНЭГТҮҮД

ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ӨРХИЙН ТОО

Сумын нэр	Өрхийн орлогын гол эх үүсвэр МАА эсэх				НИЙТ
	Тийм		Үгүй		
	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө	
Баянтэс	38	43	13	1	95
Их-Уул	34	48	11	1	94
Тосонцэнгэл	21	23	38		82
Тэс	28	35	29	3	95
БҮГД	121	149	91	5	366

ХҮСНЭГТ 2. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ТОО

Сумын нэр	Судалгаанд оролцогчийн хүйс ба насны бүлэг								Нийт
	Эмэгтэй				Эрэгтэй				
	<24 нас	25-34 нас	35-50 нас	50+ нас	<24 нас	25-34 нас	35-50 нас	50+ нас	
Баянтэс	5	43	24	5	0	11	6	1	95
Их-Уул	6	40	26	1	0	8	12	1	94
Тосонцэнгэл	2	22	27	4	0	10	16	1	82
Тэс	5	29	38	5	0	11	4	3	95
БҮГД	18	134	115	15	0	40	38	6	366

ХҮСНЭГТ 3. 0-5 НАСТАЙ ХЭДЭН ХҮҮХЭД УГ ТУСЛАМЖИЙН МӨНГИЙГ АВСАН БЭ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
1 хүүхэд	267	73.0	73.0
2 хүүхэд	93	25.4	98.4
3 хүүхэд	6	1.6	100.0
БҮГД	366	100.0	

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН СУДАЛГАА 2020 ОН

ХҮСНЭГТ 4. ЦАГ УУРЫН ХҮНДРЭЛТЭЙ ҮЕД 0-5 НАСТАЙ ХҮҮХДҮҮДЭД МӨНГӨН ТУСЛАМЖ ОЛГОХ ТАЛААР ТА ХАМГИЙН АНХ ХЭНЭЭС СОНССОН БЭ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Сумын засаг дарга	50	13.7	13.7
Банк	46	12.6	26.2
Сумын Facebook групп	17	4.6	30.9
Мал тооллогын комисс / Малын тэжээл хүр	8	2.2	33.1
Багийн засаг дарга	34	9.3	42.4
Нийгмийн халамжийн мэргэжилтэн	11	3.0	45.4
Цэцэрлэгийн багш	7	1.9	47.3
Сумын бусад төрийн албан хаагчид	37	10.1	57.4
Бусдын ярианаас	96	26.2	83.6
ТВ, радио	36	9.8	93.4
Ямар ч мэдээлэл аваагүй	14	3.8	97.3
Бусад	10	2.7	100.0
БҮГД	366	100.0	

ХҮСНЭГТ 5. ТУСЛАМЖИЙН ТАЛААРХ ХАМГИЙН ЗӨВ МЭДЭЭЛЛИЙГ ХЭН ӨГСӨН БЭ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Сумын засаг дарга	47	12.9	12.9
Банк	71	19.5	32.4
Сумын Facebook групп	13	3.6	36.0
Мал тооллогын комисс / Малын тэжээл хүргэсэн хүмүүс	9	2.5	38.5
Багийн засаг дарга	38	10.4	48.9
Нийгмийн халамжийн мэргэжилтэн	18	5.0	53.9
Цэцэрлэгийн багш	9	2.5	56.3
Сумын бусад төрийн албан хаагчид	38	10.4	66.8
Бусдын ярианаас	63	17.3	84.1
ТВ, радио	37	10.2	94.2
Ямар ч мэдээлэл аваагүй	14	3.9	98.1
Бусад	7	1.9	100.0
БҮГД	366	100.0	

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН СУДАЛГАА 2020 ОН

ХҮСНЭГТ 6. ТА УГ ТУСЛАМЖИЙН МӨНГӨНИЙ ЗОРИЛГЫГ ЮУ ГЭЖ ОЙЛГОСОН БЭ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Зудтай/ өвөлжилт хүндэрсэн сумдын хүүхдүүдэд зориулсан	191	50.8	52.3
Зөвхөн хүүхдүүдэд	104	27.7	28.5
Өрхийн өвөлжилтийг давахад	15	4.0	4.1
Бусад	43	11.4	11.8
Мэдэхгүй	23	6.1	6.3
БҮГД	376	100.0	103.0

ХҮСНЭГТ 7. ТА МЭДЭЭЛЛИЙГ МӨНГӨ ОРОХООС ӨМНӨ АВСАН УУ, ЭСВЭЛ ДАРАА НЬ АВСАН УУ?

Хугацаа	Байршил		Нийт
	Сумын төв	Хөдөө	
Өмнө	93	60	153
Дараа	102	85	187
Санахгүй байна	4	3	7
БҮГД	199	148	347

ХҮСНЭГТ 8. ТА МӨНГӨНИЙ ИХЭНХ ХЭСГИЙГ ЮУНД ЗАРЦУУЛСАН БЭ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Хүнс	39	10.7	10.7
Түлээ, түлш бэлтгэх	3	0.8	11.5
Гэрээ дулаалах	1	0.3	11.8
Хүүхдийн хувцас, гутал	112	30.6	42.4
Хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ, эм авсан	83	22.7	65.0
Насанд хүрсэн хүний эрүүл мэндийн үйлчилгээ	4	1.1	66.1
Малын тэжээл	13	3.6	69.7
Хадгаламжид хийсэн	56	15.3	85.0
Одоогийн байдлаар аваагүй, зарцуулаагүй	36	9.8	94.8
Бусад	19	5.2	100.0
БҮГД	366	100.0	

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН СУДАЛГАА 2020 ОН

ХҮСНЭГТ 9. МӨНГӨНИЙ ДАРААГИЙН ГОЛ ЗАРЦУУЛАЛТ ЮУНД ЗОРИУЛАГДСАН БЭ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Хүнс	52	32.7	32.7
Түлээ, түлш бэлтгэх	3	1.9	34.6
Хүүхдийн хувцас, гутал	32	20.1	54.7
Хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ, эм авсан	55	34.6	89.3
Насанд хүрсэн хүний эрүүл мэндийн үйлчилгээ	1	0.6	89.9
Малын тэжээл	2	1.3	91.2
Хадгаламжид хийсэн	3	1.9	93.1
Одоогийн байдлаар аваагүй, зарцуулаагүй	2	1.3	94.3
Бусад	9	5.7	100.0
БҮГД	159	100.0	

ХҮСНЭГТ 10. ТА МӨНГИЙГ ЗАРЦУУЛАХДАА ТУХАЙН ХҮҮХДЭД ЭСВЭЛ ӨРХИЙН БУСАД ГИШҮҮДЭД ХЭМЖЭЭГЭЭР ЗАРЦУУЛСАН УУ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Тухайн хүүхдэд өөрт нь	241	65.9	65.9
Бүх хүүхдэд	47	12.8	78.7
Өрхийн бүх гишүүдэд	78	21.3	100.0
БҮГД	366	100.0	

ХҮСНЭГТ 11. УГ ТУСЛАМЖ ОЛГОСОН ХУГАЦААГ ТА ОРОЙТСОН, ЭСВЭЛ ЭРТЭДСЭН ГЭЖ БОДОЖ БАЙНА УУ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Оройтсон	5	1.4	1.4
Эртэдсэн	1	0.3	1.6
Яг зөв үед	348	95.1	96.7
Мэдэхгүй	12	3.3	100.0
БҮГД	366	100.0	

ХҮСНЭГТ 12. ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХАД ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ТУСЛАМЖИЙГ ХЭЗЭЭ ОЛГОХ ХЭРЭГТЭЙ ГЭЖ ТА ҮЗЭЖ БАЙНА ВЭ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
10-р сард	4	22.2	22.2
11-р сарын эхээр	1	5.6	27.8
12-р сард	4	22.2	50.0
1-р сард	2	11.1	61.1
Бусад	7	38.9	100.0
БҮГД	18	100.0	

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН СУДАЛГАА 2020 ОН

ХҮСНЭГТ 13. ТА АЛЬ НЭГ ДЭЛГҮҮРТ ӨРТЭЙ ЮУ? ТИЙМ БОЛ УГ МӨНГӨӨ ДЭЛГҮҮРТ ӨРӨӨ ТӨЛӨХӨӨС ИЛҮҮ ХҮҮХДЭДЭЭ ЗАРЦУУЛАХАД САНАА ЗОВОХ ҮЙЛ БАЙСАН УУ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Тийм	68	18.6	18.6
Үгүй	208	56.8	75.4
Дэлгүүрт өр байхгүй	87	23.8	99.2
Мэдэхгүй	3	0.8	100.0
БҮГД	366	100.0	

ХҮСНЭГТ 14. ТАНАЙ ӨРХ ЗГ, ОРОН НУТГААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ ҮНЭЭР ОЛГОСОН МАЛЫН ТЭЖЭЭЛЭЭС ХУДАЛДАЖ АВСАН УУ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Тийм	136	37.2	37.2
Үгүй	228	62.3	99.5
Мэдэхгүй	2	0.6	100.0
БҮГД	366	100.0	

ХҮСНЭГТ 15. ТАНАЙ ӨРХ ЭНЭ ӨВӨЛ ЗГ, БУСАД ТББ-ААС ЗОХИОН БАЙГУУЛСАН МАЛЧДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЯМАР НЭГ ТУСЛАМЖИД ХАМРАГДСАН УУ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Үгүй	359	98.1	98.1
Тийм, бэлэн мөнгө авсан	1	0.3	98.4
Тийм, малын тэжээл, эм, тариа, витамин зэргийг авсан	4	1.1	99.5
Тийм, өөр төрлийн тусламж	2	0.6	100.0
БҮГД	366	100.0	

ХҮСНЭГТ 16. ТА УГ ТУСЛАМЖИЙН МӨНГӨНИЙ ТАЛААРХ СЭТГЭЛ ХАНАМЖАА ХЭЛНЭ ҮҮ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Зарим талаараа сэтгэл хангалуун бус	3	0.8	0.82
Дунд зэрэг	11	3.0	3.83
Сэтгэл хангалуун	131	35.8	39.62
Маш их сэтгэл хангалуун	221	60.4	100.0
БҮГД	366	100.0	

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН СУДАЛГАА 2020 ОН

ХҮСНЭГТ 17. СЭТГЭЛ ХАНГАЛУУН БУС БАЙГААГИЙН ГОЛ ШАЛТГААН НЬ ЮУ ВЭ?

	Давтамж	Хариултад эзлэх хувь	Өрхөд эзлэх хувь
Хүүхдийг сонгосон байдал	5	27.8	35.7
Мэдээлэл хүргэсэн байдал/ харилцаа	3	16.7	21.4
Мөнгөний хэмжээ	6	33.3	42.9
Бусад	4	22.2	28.6
БҮГД	18	100.0	128.6

Valid cases: 14

ХАВСРАЛТ 2. СУДАЛГААНЫ АСУУЛГА

Заавар

1. Судалгааны оролцогч /хариулагч/ хэн байх вэ?

Судалгааны ярилцлагыг хийх оролцогчийг сонгохдоо 12-р сард тусламжийн мөнгийг авч, захиран зарцуулсан гишүүнийг сонгоно. Энэ тохиолдолд заавал 0-5 настай хүүхдийн эцэг, эх байх ёсгүй гэдгийг санах хэрэгтэй. Учир нь зарим хүүхдүүд хамаатан садантайгаа амьдарч байдаг.

Гэхдээ тухайн гишүүнд судалгаанд оролцох боломжгүй тохиолдолд уг мөнгөний зориулалт, зарцуулалтын талаар сайн мэдэх гишүүнтэй ярилцлагыг хийнэ үү.

2. Судалгааны нэг ярилцлагад 1-ээс олон хүн хамрагдаж болох уу?

Тийм. Тусламжийн мөнгөний зориулалт, зарцуулалтын талаар мэдэж байгаа өрхийн бүх гишүүд хамтран ярилцлагад оролцох боломжтой.

Нэг өрхөд байгаа хүүхдүүдийн мөнгийг тус тусдаа авсан гишүүн тус бүр судалгаанд оролцоно. Энэ тохиолдолд судалгааны 2 тусдаа асуулгаар судалгаа авах хэрэгтэй. /Нэг гэрт 2 өрх байгаа тохиолдолд мөн хамаарна/.

3. Өрхөд хүүхдүүд нь байхгүй байгаа, тусдаа амьдардаг бол судалгаанд хамрагдах уу?

Тийм. Олон тохиолдолд эцэг, эхчүүд хэдийгээр хүүхэдтэйгээ хамт амьдраагүй байгаа ч ЗГ-с олгодог хүүхдийн мөнгийг дансаар нь хүлээн авдаг. Хэрэв тухайн эцэг, эх 12-р сард тусламжийн мөнгийг ч хүлээн авсан бол судалгаанд оролцоно.

4. Хариулт код нь цифрээр дугаарлагдсан бол зөвхөн 1 хариулт, үсгээр дугаарлагдсан бол 2 ба түүнээс олон хариулт сонгох боломжтойг гэдгийг анхаарна уу. Олон хариулттай асуултын үед судалгаанд оролцогчтой харилцан яриаг өрнүүлж боломжит бүх хариултыг авна уу.

Хэсэг А: Өрхийн байршил			
Но.	Асуулт	Хариулт	Үсрэлт
1	Өрхийн харьяа сумын нэр	10. Баянтэс 25. Их-Уул 40. Тосонцэнгэл 49. Тэс 99. Бусад	
2	Өрхийн дугаар		
3	Танай өрхийн үндсэн байршил хаана вэ?	1. Аймгийн төв 2. Сумын төв 3. Хөдөө	
Хэсэг В: Судалгаанд оролцогчийн мэдээлэл			
4	Та 0-5 настай хүүхэдтэй ямар хамааралтай вэ?	1. Эцэг, эх (биологийн, үрчилсэн, хойд) 2. Өвөө, эмээ	

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН СУДАЛГАА 2020 ОН

		<ol style="list-style-type: none"> 3. Ах, эгч, дүү 4. Бусад хамаатан (авга/нагац/үеэл) 5. Хамааралгүй 6. Бусад 	
5	Та хэдэн настай вэ?	Тоо	
6	Оролцогчийн хүйс	<ol style="list-style-type: none"> 1. Эмэгтэй 2. Эрэгтэй 3. Бусад /Хэлэхгүй байж болно/ 	
7	Танай өрхийн орлогын хамгийн гол эх үүсвэр мал аж ахуй мөн үү?	<ol style="list-style-type: none"> 1. Тийм 2. Үгүй 	
8	Өнгөрсөн 12-р сард танай сумын 0-5 настай хүүхдүүдэд “Хүүхдийн мөнгө”-ний дансаар нь дамжуулан цаг уурын хүндрэлтэй холбоотой цочролын үед хүүхдэд үзүүлэх мөнгөн тусламжийг олгосон талаар Та сонссон уу?	<ol style="list-style-type: none"> 1. Тийм 2. Үгүй (Судлаач нь уг тусламжийн зорилгыг танилцуулж, энэ нь зөвхөн нэг удаагийн туршилтын ажил байсныг хэлнэ. 	Үгүй бол тусламжийн мөнгийг авсан, эсвэл хэрхэн зарцуулсан гишүүнтэй холбогдох. Олдоогүй бол ярилцлагыг дуусгах.
9	0-5 настай хэдэн хүүхэд уг тусламжийн мөнгийг авсан бэ?	<ol style="list-style-type: none"> 1. Байхгүй (Ярилцлагыг дуусгана, зорилтот өрх биш байна) 2. 1 3. 2 4. 3 5. 4 6. 5 ба түүнээс их 	Байхгүй бол ярилцлагыг дуусгах. Энэ өрх нь зорилтот өрх биш байна.
Хэсэг С: Мэдээлэл түгээлт/ харилцаа			
10	Цаг уурын хүндрэлтэй үед 0-5 настай хүүхдүүдэд мөнгөн тусламж олгох талаар Та хамгийн анх хэнээс сонссон бэ?	<ol style="list-style-type: none"> 1. Сумын засаг дарга 2. Банк 3. Сумын Facebook груп 4. Мал тооллогын комисс / Малын тэжээл хүргэсэн хүмүүсээс 5. Багийн засаг дарга 6. Нийгмийн халамжийн мэргэжилтэн 7. Цэцэрлэгийн багш 8. Сумын бусад төрийн албан хаагчид 9. Бусдын ярианаас 10. ТВ, радио 11. Ямар ч мэдээлэл аваагүй 12. Бусад /Тодорхой бичнэ үү/ 	

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН СУДАЛГАА 2020 ОН

		_____)	
11	Тусламжийн талаарх хамгийн зөв мэдээллийг хэн өгсөн бэ?	<ol style="list-style-type: none"> 1. Сумын засаг дарга 2. Банк 3. Сумын Facebook груп 4. Мал тооллогын комисс / Малын тэжээл хүргэсэн хүмүүс 5. Багийн засаг дарга 6. Нийгмийн халамжийн мэргэжилтэн 7. Цэцэрлэгийн багш 8. Сумын бусад төрийн албан хаагчид 9. Бусдын ярианаас 10. ТВ, радио 11. Ямар ч мэдээлэл аваагүй 12. Бусад /Тодорхой бичнэ үү/ _____) 	
12	Та уг тусламжийн мөнгөний зорилгыг юу гэж ойлгосон бэ? Олон сонголттой байж болно.	<ol style="list-style-type: none"> a. Зудтай/ өвөлжилт хүндэрсэн сумдын хүүхдүүдэд зориулсан b. Зөвхөн хүүхдүүдэд c. Өрхийн өвөлжилтийг давахад d. Мэдэхгүй e. Бусад (Тодорхой бичнэ үү _____) 	
13	Уг мөнгөн тусламж өнгөрсөн 12-р сарын 9-ний өдөр хүүхдийн дансанд орсон. Та мэдээллийг мөнгө орохоос өмнө авсан уу, эсвэл дараа нь авсан уу?	<ol style="list-style-type: none"> 1. Өмнө 2. Дараа 3. Санахгүй байна 	
Хэсэг D: Мөнгөний зарцуулалт, тусламж олгосон хугацаа			
14	Та тусламжийн мөнгийг зарцуулсан уу. Мөнгөний ихэнх хэсгийг юунд зарцуулсан бэ?	<ol style="list-style-type: none"> 1. Хүнс 2. Түлээ, түлш бэлтгэх 3. Гэрээ дулаалах 4. Хүүхдийн хувцас, гутал 5. Хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ, эм авсан 6. Насанд хүрсэн хүний эрүүл мэндийн үйлчилгээ, эм авсан 7. Малын тэжээл 8. Малын эм, тариа 9. Банкны өр төлсөн 10. Дэлгүүрийн өр төлсөн 11. Хадгаламжид хийсэн 12. Одоогийн байдлаар аваагүй, зарцуулаагүй 13. Бусад (Бичих _____) 	
15	Мөнгөний дараагийн гол зарцуулалт юунд зориулагдсан бэ?	<ol style="list-style-type: none"> 1. Хүнс 2. Түлээ, түлш бэлтгэх 3. Гэрээ дулаалах 	

		<ol style="list-style-type: none"> 4. Хүүхдийн хувцас, гутал 5. Хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ, эм авсан 6. Насанд хүрсэн хүний эрүүл мэндийн үйлчилгээ, эм авсан 7. Малын тэжээл 8. Малын эм, тариа 9. Банкны өр төлсөн 10. Дэлгүүрийн өр төлсөн 11. Хадгаламжид хийсэн 12. Одоогийн байдлаар аваагүй, зарцуулаагүй 13. Бусад (Бичих _____) 	
16	<p>Энэ мөнгөн тусламж нь хүүхдэд хэрэгтэй зүйлсийг авах, өрхийн дундын хэрэглээг хангах зэргээр хүүхдийн сайн сайхны төлөө зарцуулагдах зорилготой байсан.</p> <p>Та мөнгийг зарцуулахдаа өрхийн бүх гишүүдэд тодорхой хэмжээгээр зарцуулсан уу? Үгүй бол бүх хүүхдэд эсвэл зөвхөн тухайн хүүхдэд өөрт нь зарцуулсан уу? (Шууд хадгаламжид хийсэн бол тухайн хүүхдэд өөрт нь гэж сонгоно уу)</p>	<ol style="list-style-type: none"> 1. Тухайн хүүхдэд өөрт нь 2. Бүх хүүхдэд 3. Өрхийн бүх гишүүдэд 	
17	<p>Уг тусламжийг өвөлжилт хүндэрч болзошгүй тул хүүхдийн өвлийн бэлтгэлийг хангахад зориулж олгосон. Уг тусламж олгосон хугацааг Та оройтсон, эсвэл эртэдсэн гэж бодож байна уу?</p>	<ol style="list-style-type: none"> 1. Оройтсон 2. Эртэдсэн 3. Яг зөв үед (Асуулт 19-рүү) 4. Мэдэхгүй 	Асуулт 19
18	<p>Өвөлжилтийн бэлтгэлийг хангахад хүүхдэд зориулсан тусламжийг хэзээ олгох хэрэгтэй гэж Та үзэж байна вэ?</p>	<ol style="list-style-type: none"> 1. 9-р сард 2. 10-р сард 3. 11-р сарын эхээр 4. 11-р сарын сүүлээр 5. 12-р сард 6. 1-р сард 7. Бусад 	
19	<p>Та аль нэг дэлгүүрт өртэй юу? Тийм бол уг мөнгөө дэлгүүрт өрөө төлөхөөс илүү хүүхдэдээ</p>	<ol style="list-style-type: none"> 1. Тийм 2. Үгүй 3. Дэлгүүрт өр байхгүй 4. Мэдэхгүй 	

	зарцуулахад санаа зовох үйл байсан уу?		
Хэсэг F: Зудын нөлөө & Бусад тусламж			
20	Танай өрх ЗГ, орон нутгаас хөнгөлөлттэй үнээр олгосон малын тэжээлээс худалдаж авсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
21	Танай өрх энэ өвөл ЗГ, бусад ТББ-аас зохион байгуулсан малчдад дэмжлэг үзүүлэх ямар нэг тусламжид хамрагдсан уу? Олон хариулт сонгох боломжтой	a. Үгүй b. Тийм, бэлэн мөнгө авсан c. Тийм, малын тэжээл, эм, тариа, витамин зэргийг авсан d. Тийм, өөр төрлийн тусламж (Тодорхой бичнэ үү _____)	
Хэсэг G: Сэтгэл ханамж			
22	Та уг тусламжийн мөнгөний талаарх сэтгэл ханамжаа хэлнэ үү?	1. Огт сэтгэл ханамжгүй 2. Зарим талаараа сэтгэл хангалуун бус 3. Дунд зэрэг 4. Сэтгэл хангалуун 5. Маш их сэтгэл хангалуун	
23	Хэрвээ 3, түүнээс бага оноо өгсөн бол, сэтгэл хангалуун бус байгаагийн гол шалтгаан нь юу вэ? Олон хариулт сонгох боломжтой	a. Хүүхдийг сонгосон байдал (хүүхдийн нас, сумын сонголт г.м) b. Мөнгө олгосон хугацаа c. Мэдээлэл хүргэсэн байдал/ харилцаа d. Мөнгөний хэмжээ e. Бусад (Тодорхой бичнэ үү _____)	